

Дамчаабадгарын Содномжамц¹*, Нацагийн Батболд¹

¹Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Хороон орой уулын хадны зураг дахь шувууны дүрслэл

Товчлол. Монгол нутагт оршин амьдарч байсан эртний нүүдэлчдийн ахуй амьдралд шувуу хэмээх тэнгэрийн амьтан тодорхой хэмжээнд дээдлэн шүтэгдэж ирсэн болохыг археологийн эх сурвалжууд болох хадны зураг, булш оршуулгын дурсгалаас олдсон олдвор хэрэглэгдэхүүн нотлон харуулдаг. Харин шувууг нүүдэлч малчид хэдий үеэс эхлэн эрхэмлэн үзэх болсон бэ гэдэг асуудал судалгааны нэгэн сонирхолтой сэдэв болохын зэрэгцээ тэдний шүтлэг бишрэлийн талаарх ойлголтыг лавшруулан судлахад тус нэмэр болохуйц чухал өгүүлэмж бол хадны зураг дахь шувууны дүрслэлүүд юм. Дээрх судалгааны асуудлыг тодруулах зорилгоор бид Увс аймгийн Давст сумын Хороон орой уулын хадны зураг дахь шувууны (бүргэд) дүрслэлийг бусад бүс нутгаас олдсон ижил төстэй материалтай харьцуулан үзэхэд бүх талаараа шүтлэг бишрэлийн агууламжтай зураг болох нь харагдаж байна. Шувуудын дотроос тоодог, тогоруу, хойлог, галуу, ногтруу зэрэг нь эртний хүмүүсийн хоол хүнсний хэрэгцээг хангах нэгэн эх үүсвэр бол хүчирхэг махчин шувуудыг харин дээдлэн шүтэж улмаар ан авд сурган ашиглах болсон нь Монгол нутагт хүрлийн хожуу үеэс эхэлж улмаар төмрийн түрүү үе гэхэд илүү боловсронгуй болж, дараа дараагийн түүхэн үеүдэд уламжлагдан хөгжжээ. Харьцуулсан судалгаанаас харахад Хороон орой уулын хадны зураг дахь шувууны дүрслэлийг төмрийн түрүү үе буюу Чандмань-Сагилын соёлд хамруулан үзэж байна.

Түлхүүр үг. Шувуу, хадны зураг, төмрийн түрүү үе, шүтлэг бишрэл

Sodnomjamts Damchaabadgar¹*, Batbold Natsag¹

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Depiction of Bird at Khoroon oroi Mountain's Petroglyph

Abstract. Archeological sources such as petroglyphs and artifacts found in burial monuments show that birds were revered to a certain extent in the lives of ancient nomads living in Mongolia. However, the question of when birds were worshiped by nomadic herders is an interesting topic of research, as well as an important narrative that can contribute to the study of the understanding of their worship. In this paper, narattes the comparison of a bird (eagle) image in the rock art of Khoroon Oroi mountain in Dast soum, Uvs aimag with similar materials found in neighbour regions. Some species of birds were a source of food for the ancient people, while powerful birds of prey were worshiped and used for hunting, which began in the Bronze Age in Mongolia and became more sophisticated by the Early Iron Age and continued to develop in subsequent historical periods.

Keywords. Birds, rock art, Early Iron Age, worship

**Дурсгалт газрын байршил,
судалгааны хэрэглэгдэхүүн**

Хороон орой уулын хадны зургийн дурсгалт газар нь Увс аймгийн Давст сумын төвөөс баруун хойд зүгт 35 км зайд Хандгайт багийн нутагт оршдог (Зураг 1). Энэхүү дурсгалт газрыг анх 2022 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид хадны зургийн хайгуул судалгааны ажлын явцад илрүүлсэн ба улмаар 2023 онд Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж хамгаалах” төслийн хүрээнд хадны

зургийн нийт тархалтын бүсийг тогтоох зорилгоор хадны зурагтай хавтан чулуу бүрийн байршлын цэгийг авч, гэрэл зургаар баримтжуулах ажил хийж гүйцэтгэв [Батболд нар, 2023: 51]. Баруун Тагны нурууны салбар Хороон орой хэмээх уул нь Монгол улсын хилийн бүсэд байрладаг. Хороон орой уулын зүүн талд Бургаст уул, зүүн урд Бичигт хаяагийн хадны зургийн дурсгал бий. Хороон орой уул нь энгэр хэсгээрээ боржингийн төрлийн чулуун тогтоц бүхий хавтгай хадтай бөгөөд уулын урд энгэр болон бэлд орших хадны зургийн



Зураг 1. Хороон орой уулын байршилгыг газрын зурагт тэмдэглэсэн байдал

тархалтын байдлаас хамааран бид хоорондоо нарийн жалгаар зааглагдсан талбайнуудыг дотор нь 5 хэсэгт хувааж баримтжуулалтын ажил хийв. Үүнээс I талбайд 78 хавтан, II талбайд 51 хавтан, III талбайд 18 хавтан, IV талбайд 20 хавтан, V талбайд 21 хавтан буюу нийт 198 хавтан чулуун дээр 2000 орчим тооны дүрслэл бий. Эдгээр зургууд нь он цагийн хувьд хүрлийн хожуу үеэс Уйгурын үе хүртэлх хугацаанд хамаарах бөгөөд бид энэ удаад зөвхөн шувууны дүрслэлийн тухайд дэлгэрэнгүй өгүүлэх болно.

Шувууны дүрслэл. Бидний энд онцлон өгүүлж буй шувууны дүрслэл нь Хороон орой уулын баруун урд талын энгэрийн дунд хэсэгт байрлах зүүн урд зүг рүү харсан 152 x 120 см хэмжээтэй хавтгай хаданд (IV-12) байрлана. Энэхүү хавтангийн зүүн хэсэгт далавчаа дэлгэн нисэж буй нэгэн шувуу, түүний баруун доор ижил төрлийн өөр нэг жижиг шувуу, баруун хэсэгт буга, хоёр янгирын дүрслэл бий. Эдгээр амьтдыг бүгд их биеийг хөвөөлдөн цохих аргаар зурсан байна. 1-р шувуу нь 46 x 30 см буюу харьцангуй том хэмжээтэй ба биеийн хэсгүүдийг бодит байдлаар тод харуулжээ. Тухайлбал, монхор хошуутай, дугуй хэлбэрийн нүдтэй ба толгойг зүүн тийш харуулж, хүзүүг эх биеэс нарийн зураасаар ялган зааглаж, биеийн доод хэсэгт гурван хумстай сарвуугаа хумин барьж, хоёр далавчаа дэлгэн дүүлэн нисэж буй байдлаар дүрсэлжээ. Далавчийг хоёр талд дэвүүр өдийг тус бүр 0.5 см өргөнтэй 12 ширхэг нарийн зураасаар намирсан байдлаар зурсан ба хамгийн урт нь 17 см байна. Харин сүүлний хэсэгт залуур өдийг тусад нь 11 ширхэг зураасаар эх биеэс салган дүрсэлжээ. 2-р шувууг баруун доор нь


10 см-ын зайд 29 x 23 см хэмжээтэй жижиг байдлаар сийлсэн ба дүрслэлийн хувьд дээрхтэй ижил нэг төрлийн шувуу боловч далавчийг 3, залуурыг 4 ширхэг өдтэйгөөр тойм төдий гаргажээ. Энэ нь магадгүй өд сөд бүрэн ургаж амжаагүй ангаахай бололтой (Зураг 2).

Дээрх хоёр шувууг гурван хумстай сарвуугаа доороо хумин барьснаар дүрсэлсэн нь урлаач шувууг тэнгэрт дүүлэн нисэх үед доороос нь харсан байдлаар зурсан болохыг илтгэнэ. Шувууны биеийн ерөнхий хэлбэр, хошуу, сарвуу, далавч зэрэг дүрслэлээс харахад махчин төрлийн шувуу болох нь мэдэгдэх бөгөөд бүргэд болов уу хэмээн таамаглаж байна.

Бүргэд нь урдаа гурав, ардаа нэг нийт дөрвөн сарвуутай боловч нисэх үед зөвхөн урд талын гурван хумс харагдах тул энэ байдлыг урлаач нарийн бодолцон хаданд дүрслэн харуулжээ. Уулархаг бүсэд амьдардаг цармын бүргэдийн (*Aquila chrysaetos*) зүс нь бараан тул түүний хошуу, хумсны угийг бүрсэн хурц шар өнгийн арьс нь алсаас сайн ялгаран харагддаг аж [Эрдэнэбат, 2014: 212].

Харьцуулсан судалгаа

Монгол орны хадны зураг дахь хамгийн эртний шувууны дүрслэлд одоогоор Ховд аймгийн Манхан сумын Хойд Цэнхэрийн агуй [Окладников, 1972: 26], Дорнод аймгийн Баян-Уул сумын Хар чулуут [Эрдэнэбат, 2023:16] Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Арал толгой [Цэвээндорж



Зураг 2. Хороон орой уулын хадны зураг дахь шувууны дүрслэл

нар, 2005: 56] зэрэг газрын дээд палеолитоос мезолитын үед хамаарах тэмээн хяруулын зураг тооцогддог. Эдгээр нь дүрслэлийн хувьд бидний өгүүлэн буй Хороон орой уулын хадны зургийн шувуунаас өөр төдийгүй, он цагийн хувьд ч хамаагүй эрт үед холбогдох нь тодорхой юм. Харин хүрлийн хожуу, төмрийн түрүү үеийн хадны зурагт шувууг дүрслэхдээ тухайн шувууны төрөл зүйлээс хамаарч биеийн өвөрмөц шинжийг заавал онцгойлон урласан болох нь шууд мэдэгдэх бөгөөд ихэвчлэн газарт зогсож эсвэл явж буй болон тэнгэрт дүүлэн нисэж буй байдлаар зурсан үндсэн хоёр төрөл байна. Урт эсвэл богино хөл, нарийн уртлаг хүзүүтэй тогоруу, тоодог, нугас зэрэг тал хээрийн бүсийн шувууг зогсож буй эсвэл сүргээрээ явж байгаа байдлаар ихэвчлэн дүрслэх бол зарим тохиолдолд эдгээр шувуудыг нум сумтай анчин агнаж эсвэл бусад амьтдын хамтаар зурсан сэдэв зохиомжууд элбэг бий. Харин бүргэд, тас, харцага, шонхор зэрэг шувуудыг нисэж болон тураг, загас зэрэг амьтдыг авлаж буй байдлаар дүрслэхийн зэрэгцээ шүтлэг бишрэлийн утга агуулгатай зургууд ч судалгааны сонирхолтой сэдэв болж байна.

Хороон орой уулын хадны зураг дахь дүүлэн нисэж буй шувууны далавч, махир хошуу, сарвуу зэргийг бодитойгоор урлан харуулсан нь түүнийг таних гол онцлог шинж хэмээн үзэж болно. Хоёр далавчийг их биеэс залгуулан гадагш намируулж, хөл болон сарвууг онцлон дүрсэлсэн зураг одоогоор Монгол нутгаас мэдэгдээгүй байна. Харин Баян-Өлгийн аймгийн Улаанхус сумын Бага Ойгур, Цагаан салаагийн хадны зурагт 20 гаруй [Кубарев и др, 2005: 556, Рис.66], Шивээт хайрхны хадны зурагт 7 тооны шувууны дүрслэл тус тус тэмдэглэгдэжээ [Цэвээндорж нар, 2010: 59, зур. 356, 622] (Зураг 3). Эдгээрээс зарим шувуудын дүрслэл бидний өгүүлэн буй зурагтай төстэй боловч далавчийг нэг шулуун шугамаас доош цацарсан олон зураасаар эсвэл бүх талбайгаар нь хонхойлгон цохих аргаар урласан байгаагаараа бага зэргийн ялгаатай байна.

Хүрэл зэвсгийн үеэс шувуу нь шүтлэгийн нэгэн дүр болж дэлгэрсэн ба шувууны дүрслэл энэ үеийн хадны зураг төдийгүй овор ихт урлагийн дурсгал,



Зураг 3. Монгол Алтайн хадны зураг дахь шувууны дүрслэл.
1. Цагаан салаа, Бага Ойгур [Кубарев и др. 2005],
2. Шивээт хайрхан [Цэвээндорж нар 2010],

чимэглэх урлагийн бусад дурсгалаас тодорхой харагддаг [Цэрэндагва, Цэвээндорж, 2016: 124]. Тухайлбал Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Далан Түргэний хос толгойн ан авын байдлыг харуулсан нэгэн зургийн дээд хэсэгт хоёр бүргэд сийлсэн нь тотем шүтлэгийн илэрхийлэл байж болно [Цэрэндагва, Цэвээндорж, 2016: 60, зур. 570] хэмээжээ. Өөр нэгэн тодорхой баримт бол “Сэлэнгийн” хэмээн нэрлэгддэг хадны зосон зураг дахь дөрвөлжин болон зуван дугуй хүрээний дээд талд буй шувууны (бүргэд) дүрслэл бөгөөд үүнийг судлаачид тахин шүтдэг шүтээн [Дорж, 2019: 43; Наваан, 1975: 53], аюулаас хамгаалах гэсэн санаа [Цэвээндорж, 1977: 32], оршуулгын зан үйлийн үед тэнгэртэй холбогдох зууч [Амартүвшин, 2002: 18, Батсайхан, 2003: 35] хэмээн тайлбарласан байдаг. Мөн доктор Д.Одсүрэн хүрээн доторх цэг тэмдэг нь ил оршуулга хэмээн үзсэн бөгөөд нас барагчийн сүнсийг дараагийн амьдралд хүргэх унаа хөтөч бол шувуу хэмээн итгэж байсан нь “Сэлэнгийн” зосон зураг, дөрвөлжин булшны сийлмэл зурагт илрэлээ олсон хэмээн сонирхолтой тайлбар өгчээ [Одсүрэн, 2022: 12].

Дээрхээс гадна ӨМӨЗО-ны Алшаа аймгийн Мандал уулын хадны зурагт шувууны дүрслэл цөөнгүй бий [Gai Shanlin, 1997: 245]. Тухайлбал нум сумтай анчин, морьтон болон олон тооны буга, янгир зэрэг бүхэлдээ ан авын сэдэвт зохиомжтой зургийн дээд болон дунд хэсэгт далавчаа дэлгэсэн махчин шувууг бусад дүрээс илүү томоор харуулсан нь шүтэн дээдэлж байсны илрэл хэмээн үзэх бас нэгэн жишээ юм.

Шувууг хадны зурагт дүрслэхээс гадна хөшөө чулуу болон булш оршуулгын дурсгалаас олдсон хүрэл эсвэл алтан эдлэл дээр чимэглэл болгон урлах явдал нийт Евроазийн хэмжээнд хүрлийн үеэс



Зураг 4. Хөрш зэргэлдээх бүс нутгаас хүрлийн хожуу үеийн шувууны дүрст хүрэл эдлэлүүд. 1. Наншэнгэн-гийн М4-р булш [Zhongguo 1975], 2. Зүүн хойд Хятад [Bunker, Brosseder 2022], 3. Өвөр байгалийн Дворцов хэлбэрийн булш [Кириллов 1979: 89], 4. Хэнан мужийн Санмэншиа хотын Шанцуньлин-гийн М1612-р булш [Liu Ning 2000]

эхлэн тархсан болохыг энд жишээ болгон доорх байдлаар тоймлон дурдав. Монгол нутгаас олдсон 1241 тооны буган хөшөөний дотроос зөвхөн 3 хөшөөнд шувууны дүрслэл бий [Баярсайхан, 2017: 121; Гантулга, 2021: 148]. Эдгээрээс Төв аймгийн Эрдэнэсант сумын Омгийн хөтлийн дөрвөлжин булшинд буган хөшөөг булангийн хөшөө чулуу болгон ашигласан гэхээсээ илүүтэй оршуулгын зан үйлийн учир холбогдлын үүднээс зориудаар хийсэн дөрвөлжин булшны соёлд хамаарах дүрслэлүүд мөн бололтой [Сэр-Оджав, 1965: 49]. Омгийн хөтлийн дөрвөлжин булшны хөшөө чулуун дээрх тоодогтой төстэй шувууны дүрслэл Дэл уулын “32 хүнт” хэмээх дөрвөлжин булшны хашлага чулуун дээр бий [Болдбаатар, 2017: 165] боловч энд өгүүлэн буй шувуунаас эрс ялгаатай. Харин Монгол болон хөрш зэргэлдээх бүс нутагт малтан судалсан булш оршуулгын дурсгал болон түүвэр байдлаар шувуу дүрсэлсэн гоёл чимэглэлийн зүйлс, бариулан дээрээ шувууны дүрстэй хутга зэрэг олдвор цөөнгүй олдсон бөгөөд одоогоор хамгийн эртнийх нь НТӨ VIII зуунд хамаарч байна. Тухайлбал, БНХАУ-ын Хэнан мужийн Санмэншиа хотын Шанцуньлин-гийн М1612-р булшнаас гарсан Хавар, Намрын улсын эхэн үеийн хүрэл толь [Liu Ning 2000: 14] (Зураг 4: 4), Өвөр Монголын Уухан хошуу, Нинчин хотын Наншэнгэн, Зүүн хойд Хятад (Зураг 4: 2), Өвөр Байгалийн Дворцов хэлбэрийн булшнаас [Кириллов, 1979: 89] (Зураг 4: 3) гарсан хүрэл чимэглэлүүдийг дурдаж болно [Bunker, Brosseder 2022: 62]. Эдгээрээс Сиажиадианы дээд шатны соёлд хамаарах Наншэнгэн-гийн М4-р булшнаас шувууны дүрст хүрэл чимэглэл 17 ширхэг гарсан [Zhongguo, 1975: 136] (Зураг 4: 1) шувууд нь бүгд махир хошуутай, гурван сарвуутай далавчаа дэлгэсэн махчин шувууд болох нь төвөггүй мэдэгдэнэ.

Хэлэлцүүлэг

Ер нь хадны зурагт шувууг яагаад дүрслэх

болсон бэ гэсэн асуултад тодорхой хариулт авахын тулд эхлээд тухайн дүрслэлийн утга санааг сайтар ойлгож тайлбарлах нь зүйтэй болов уу. Тиймээс шувуу дүрсэлсэн зургуудыг шүүн үзэхдээ тухайн хавтан чулуун дээрх бусад хүн, амьтны дүрүүдтэй хэрхэн холбогдох талаар анхаарч, утга санааг тайлах нь үнэнд илүү дөхнө. Хороон орой уулын хадны зураг дахь хоёр шувууны дүрслэл нь нэгэн хавтгай хадны баруун хэсгийг бүхэлд нь хамарч зурагдсан бол шувууд руу нэг буга харсан байдлаар зуржээ. Харин бугын доод талд буй янгир нь дүрслэлийн аргын хувьд ялгаатай тул арай хожуу үед хамаарна. Тиймээс тус шувууг бусад дүрээс ялган илүү томоор дүрсэлсэн нь тухайн овог аймгийн шүтээн амьтан байсан болов уу хэмээн таамаглаж байна. Дээрх харьцуулсан судалгаанаас харахад хүрлийн хожуу үеийн хадны зураг, буган хөшөөн дээрх шувууны дүрслэл, булш оршуулга болон түүвэр байдлаар олдсон хүрэл эдлэл дээрх шувуудаас Хороон орой уулын шувууны дүр ихээхэн ялгаатай байна. Харин төмрийн түрүү үеийн булшнаас гарсан хэрэглэгдэхүүнтэй илүү төстэй болохыг доорх баримтаар харьцуулан үзэж болох юм.

Пазырыкийн булшнаас гардаг амьтны загварт урлагийн бүтээлүүд дотор грифон, бүргэд, хун, тогоруу зэрэг жигүүртэн амьтдын дүрслэл элбэг тохиолддог. Түүхч Геродот МЭӨ 464 онд Грек-Персийн дайны тухай баримт цуглуулахаар олон газар орноор явж, арвин мэдээ тэмдэглэн авч улмаар 9 дэвтэр “Түүх” хэмээх зохиол бичжээ. Тус зохиолын IV дэвтэрт (melpomene) “...алт хамгаалагч грифонууд (gold guarding griffins)” [The Histories, 1904: 217] гэсэн чухал мэдээ байдгийг Алтайн нуруунд амьдарч байсан төмрийн түрүү үеийн нүүдэлчид мөн хэмээн олон орны эрдэмтэд иш татан өөрсдийн бүтээлдээ ашигласан байдаг. Энэ тухай монгол орчуулгад “...исседонуудын цаадтайд нэг нүдэт аримаснууд, тэдний цаадтайд алт хураагч грифүүд, тэднээс цааш бүр дээшээгээ тэнгистэй хиллэх хязгаарт

гипербореи нар амьдардаг. Гипербореигоос бусад ард түмэн нь хөршүүдтэйгээ үргэлж дайтаж байдаг” [Геродот, 2009: 18] хэмээжээ.

Алт хамгаалагч грифон шувууд гэдэг нь үнэн хэрэгтээ Өмнөд Сибирийн эртний нэгэн овог угсаатныг бэлгэ тэмдгээр нь төлөөлүүлсэн байж болох бөгөөд гриф - тас шувуу Евроазийн амьтны загварт урлагт цаг үе бүрд чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн байдаг [Парцингер, 2016: 37]. Тэгвэл Орос, Казакстан, Монголын нутагт малтан судалсан төмрийн түрүү үеийн Пазырык болон Чандмань-Сагилын соёлын булшнаас гарсан жигүүртэн амьтдын дүрслэл нь дээрх мэдээ баримтын нэгэн нотолгоо юм. Түүнчлэн Монгол Алтайн бүс нутгаас олдсон хадны зураг дахь далавчаа дэлгэсэн махчин шувуудын дүрслэл ч хамаарна.

Укокийн өндөрлөгт малтан судалсан Ак Алах-1 дурсгалын 1-р булш, Верх-Кальджин-2 дурсгалын 1, 3-р булш, Монгол Алтайн Олон гүүрийн (нуур) гол-10 дурсгалын 1-р булш зэргээс шовх оройтой, тогоруу шувууны хэлбэртэй эсгий малгай гарсан байдаг. Эдгээр малгайны орой болон хажуу хэсэгт эвэртэй адуу, янгир, хун, буга зэрэг амьтдын модон дүрсийг тогтоосны зэрэгцээ зарим малгайны урд талын хэсэгт далавчаа дэлгэсэн бүргэдтэй төстэй шувууны дүрслэл ч бий. Тогорууны толгой хэсгээр дүрслэн хийсэн малгайн оройн чимэглэл нь Өмнөд Алтайн Пазырыкчуудын угсаатны бүлэг эсвэл овгийн бэлгэ тэмдгийг илэрхийлсэн бололтой [Cheremisin, 2009: 92, fig.1]. Пазырык булшны оршуулгад дагалдуулсан адуунд бугын маск өмсгөсөн байгаа нь энэ насны унаа болсон адуу нь бугын дүрд хувиран хойд насанд хүргэдэг хэмээх санаа [Түвшинжаргал, Анхсанаа, 2023: 99] байж болох төдийгүй адууны тоног хэрэгсэлд ихэвчлэн грифоны дүрслэл түгээмэл бий. Нөгөө ертөнц буюу үхлийг бэлгэддэг эдгээр махчин араатнуудыг морьдын хазаар хударгад дүрсэлснээрээ бэлгэдэл зүйн хувьд үхүүлж, нөгөө ертөнцөд хүргэж байгаа хэрэг юм [Төрбат, Батсүх, 2015: 36]. Дээрхээс үзвэл пазырыкчуудын нөгөө ертөнцийн тухай ойлголтод талийгаач өөрөө шувуу болж халин одохдоо, бугын дүрд хувирсан морь хөлөглөн грифон шувуугаар чиглүүлэн дээд тэнгэрт хүрдэг гэсэн ойлголт байжээ.


Түүнчлэн хожмын бөөгийн шашинд шувуутай холбогдох зарим ойлголт хувцас хэрэгсэлд тусгалаа олсон байгаагийн дотор Дархад, Хуулар, Уйгур (цаатан), Тувагийн Тож нутгийн бөөгийн оройгүй, боолт хэлбэрийн малгайн дээд ирмэгээр бүргэдийн өд хатгах...бол Буриад, Барга, Хорчин бөөгийн малгайд буга, бор гөрөөсний эврийн дүрс болон нисэж яваа арслан, бүргэд шувууны дүрсийг бэхэлсэн байдаг [Пүрэв, 1999: 184-185] хэмээн тэмдэглэсэн нь ихэд сонирхол татна.

Пазырыкийн хаадын булшинд оршуулагдсан хүмүүс бол бөө нар байсан бөгөөд тэдний урлаг соёлд бөөгийн шашны нөлөө их байсан тул амьтны загварт урлагийн дүр дүрсүүдийг бөөгийн онгон [Черемисин, 2008: 22] гэсэн тайлбар ч бий.

Он цагийн хамаарал болон дүгнэлт

Хороон орой уулын хадны зураг дахь шувууны дүрслэлийн он цагийг магадлан тогтоохын тулд тухайн бүс нутагт хийгдсэн булш оршуулгын дурсгалаас олдсон олдворууд чухал туслах хэрэглэгдэхүүн болохын зэрэгцээ Монгол Алтайн хадны зураг дахь бусад шувууны зурагтай зайлшгүй харьцуулан судлах шаардлагатай. Дээр өгүүлсэнчлэн Цагаан салаа, Бага Ойгорын хадны зураг дахь шувууны дүрслэл Хороон орой уулын шувууны зурагтай зарим дүрслэлээрээ ялгаатай боловч энэ нь орон нутгийн онцлог шинж байхыг үгүйсгэхгүй. Эдгээрээс Цагаан салаа IV дурсгалын далавчаа дэвсэн махчин шувуу эгц доошоо шумбан нэгэн загас руу довтолж буй зураг, Бага Ойгор II дурсгалын янгир луу довтолж буй шувуудыг судлаачид Пазырыкийн соёлд хамруулан үзсэнийг онцлон дурдах хэрэгтэй [Цэвээндорж, Төрбат, 2016:128, табл.2] боловч шууд адилтган үзэж боломгүй байна. Харин ОХУ-ын Тувагийн нутаг дахь Суглуг-Хем I дурсгалт газарт малтан судалсан төмрийн түрүү үеийн булшнаас гарсан шувууны дүрст алтан чимэглэлүүдтэй Хороон орой уулын хадны зураг төстэй байна. Тухайлбал, Суглуг-Хем I дурсгалын 26-р булшны дүрслэл бунхан дотор 2 эрэгтэй, 1 эмэгтэй, 1 хүүхэд оршуулсан ба үүнээс 1-р хүний толгой орчмоос шувууны дүрсийг товойлгон урласан 23 ширхэг нимгэн алтан чимэглэл илэрснийг малгайн чимэглэл гэж үздэг. Тус язгууртан эрийн хувцас нь нийтдээ 100 гаруй алтан чимэглэлтэй бөгөөд түүний өөдөөс хүүхэд, эмэгтэй хоёрыг харуулан оршуулсан байжээ [Семенов, 2003: 20-21, табл.25] (Зураг 5: 1, 5).

Талийгаачийн толгой орчмоос анхны байрлалаараа (in situ) илэрсэн шувууны дүрст алтан чимэглэлүүд дээр тулгуурлан сэргээн зурсан малгайнаас харахад энэ нь духны хэсгээр тойруулан боосон толгойн боолт маягийн хэлбэртэй байна. Гол хэсэг буюу хүний духан дээр далавчаа дэлгэж толгойгоо зүүн тийш хандуулсан нэг том шувуу, харин баруун тийш буюу том шувуу руугаа харсан байрлалтай 22 ширхэг жижиг шувууг малгайн дээр хадаж тогтоожээ. Шувууны далавчийг нарийн зураасаар товойлгон гаргаж, сүүл буюу залуур, махир хурц хошуу, нүд зэргийг тодорхой дүрсэлснээс харахад бүргэдтэй илүү төстэй. Дээрхтэй ижил дүрслэл бүхий шувууны алтан чимэглэл Суглуг Хем I дурсгалын 13-р булшнаас 1 ширхэг (Зураг 5: 2), 29-р булшнаас 4



Зураг 5 ОХУ-ын Тувагийн нутгаас олдсон шувууны дүрст алтан чимэглэл. 1. Суглуг Хем-1 25-р булш, 2. Суглуг Хем-1 13-р булш, 3. Суглуг Хем-1 29-р булш, 4. Пий-Хемский хошууны Чкаловка-гийн булш, 5. Суглуг Хем-1 25-р булшинаас гарсан шувууны дүрст чимэглэлийг сэргээн зурсан байдал [Семенов 2003]

ширхэг (Зураг 5: 3), Догээ-Баары-2 дурсгалын 20-р булшнаас тус тус гарчээ [Алексеева и др, 2005: 157; Иконников-Галицкий, 2006: 120]. Дээрхээс Догээ-Баары-2 дурсгалын 20-р булшнаас гарсан бүргэдийн дүрст алтан чимэглэл дээрх дэвүүр болон залуур өд, махир хошуу, хөл, сарвуу болоод биеийн ерөнхий хэлбэрийн хувьд Хороон орой уулын шувууны дүрслэлтэй ижил байна (Зураг 6).

Шувуудыг ингэж том, жижгээр нь ялган дүрсэлсэн нь санамсаргүй зүйл огт биш бөгөөд том шувууг гол шүтээн болгон харуулсан



Зураг 6. Бүргэдийн дүрслэл 1. Хороон орой уулын хадны зураг, 2. Догээ-Баары-2 дурсгалын 20-р булшинаас гарсан алтан чимэглэл [Алексеева и др 2005; Иконников-Галицкий 2006]

бололтой. Хороон орой уулын зурагт буй том жижиг шувууны дүрслэл ч гэсэн дээрхтэй ижил утга санаа агуулсан байж мэднэ. Мөн Тувагийн Пий-Хемский хошууны Чкаловка-гийн орчимд малтсан нэгэн булшнаас 3 ширхэг шувууны алтан чимэглэл (Зураг 5: 4) гарсан бөгөөд судлаачид НТӨ V зуунд холбогдуулсан [Чугунов, и др. 2017: 17. рис.13] бол доктор Вл.А.Семенов Суглуг Хем-ийн дурсгалаас олдсон олдвор болон байгалийн шинжлэх ухааны аргаар тогтоосон он цагт тулгуурлан Скифийн төгсгөл буюу Озен-Ала-Белигскийн шатанд хамруулан үзсэн нь НТӨ IV-III зуун юм [Семенов, 2003: 76-81]. Тус хадны зургийн дурсалт газрын орчимд Урт бэлийн оршуулгын газар, Бичигт хаяагийн найман чулуут тахилын байгууламж зэрэг Чандмань-Сагилын соёлын тархалтын бүс нутагт хамаарах дурсгалууд байдаг нь дээрх соёлд хамруулан үзэх бас нэгэн үндэслэл болно.

Тогоруу, хун, тоодог, галуу зэрэг тал хээрийн бүсэд амьдардаг нүүдлийн шувууд нь эртний хүмүүсийн хоол хүнсний хэрэгцээг хангагч нэгэн эх үүсвэр байсан болохыг хадны зураг дахь ан авын сэдэвт зургууд нотлон харуулдаг. Харин бүргэд, тас, шонхор, харцага зэрэг хүчирхэг махчин шувуудыг дээдлэн шүтэх ойлголт хүрлийн хожуу үеэс эхлэн нүүдэлчдийн ахуй амьдралд нэвтэрсэн бөгөөд улмаар нөгөө ертөнцийн талаарх оршуулгын зан үйлийн нууцлаг ойлголттой салшгүй холбогдож, улмаар төмрийн түрүү үед хөгжлийн оргил шатанд хүрчээ. Хадны зураг дахь далавчаа дэлгэсэн махчин шувууны дүрслэл болон булш оршуулгын дурсгалаас олдсон алтан

чимэглэл зэрэгт тулгуурлан Хороон орой уулын хадны зургийн шувууны дүрийг НТӨ V-III зуунд хамаарах Чандмань-Сагилын соёлынхны шүтээн амьтдын нэг болох бүргэд хэмээн үзэж байна.

Ном зүй

Алексеев и др, 2005 – А.Ю.Алексеев., Н.А.Боковенко., С.С.Васильев., В.А.Дергачёв., Г.И.Зайцева., Н.Н.Ковалюх., Г.Кук., Й.ван дер Плихт., Г.Поснерт., А.А.Семенов, Е.М. Скотт, К.В.Чугунов. Евразия в скифскую эпоху. Радиоуглеродная и археологическая хронология. Санкт-Петербург, 2005.

Амартүвшин, 2002 – Ч.Амартүвшин. “Сэлэнгийн” зосон зургийн дүрслэл оршуулгын зан үйлтэй холбогдох нь // *Ephemeris Historiae Academiae Doctrinae Mongolici*. Tom.III, fasc. 2. Улаанбаатар, 2002.

Батболднар, 2023 – Н.Батболд, Д.Содномжамц, Ц.Цэлхагарав, Т.Түвшинжаргал. “Соёлын өвийг судалж хамгаалах” төслийн хүрээнд Увс аймгийн Давст сумын Урт бэлийн дурсгалт газарт 2023 онд хийсэн археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын тайлан, Улаанбаатар, 2023.

Батсайхан, 2003 – З.Батсайхан. “Сэлэнгийн” хэмээх зосон зургуудыг шинээр тайлбарлах нь // Археологи, антропологи, угсаатан судлал. Эрдэм шинжилгээний бичиг. Vol. 210 (19). Улаанбаатар, 2003.

Баярсайхан, 2017 – Ж.Баярсайхан. Монголын умард нутгийн буган хөшөөд. Улаанбаатар, 2021.

Болдбаатар, 2017 – Ю.Болдбаатар. Дөрвөлжин булшны хашлаганы зураг дахь бүжиг хийгээд сексийг тайлбарлах нь. “Төв Ази ба Умард Хятадын хадны зураг” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 2017.

Bunker, Brosseder, 2022 – Emma C.Bunker, Ursula Brosseder. The Guyuan Mizong Collection. A Study of Inner Asian Steppe Bronzes. Harrassowitz Verlag, 2022.

Gai Shanlin, 1997 – 盖山林《巴丹吉林沙漠岩画》北京图书馆出版社1997年。

Гантулга, 2021 – Ж.Гантулга. Амьтны дүр, дүрслэл. Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл. Гутгаар боть, Редактор Ц.Төрбат. – Улаанбаатар, 2021.

Геродот, 2009 – Геродот. Түүх. /Орчуулсан Б.Галаарид/, Улаанбаатар, 2009

Дорж, 2019 – Д.Дорж. Монголын хүрлийн үеийн хадны зураг. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл. I. Өгүүлэл, илтгэл. Эрхэлсэн Д.Цэвээндорж, Б.Цогтбаатар. Улаанбаатар, 2019.

Zhongguo, 1975 – 中国科学院考古研究所内蒙古工作队《宁城南山遗址发掘报告》考古学报1975年第一期。

Иконников-Галицкий, 2006 – А.А.Иконников-Галицкий. Догээ-Баары - сердце сфинкса. Наука из первых рук, Ноябрь, 2006. №6(12).

Кириллов, 1979 – И.И.Кириллов. Восточное Забайкалье в древности в средневековье. Иркутск, 1979.

Liu Ning, 2000 – 刘宁《北方式动物纹青铜镜》北方文物2000年第3期。

Одсүрэн, 2022 – Д.Одсүрэн. Нүүдэлчдийн оршуулгын ёслол дахь шувуутай холбогдох зан үйлийг нягтлах нь. // *Acta Historica Mongolica*. Tomus XXIII, Fasc.1, Улаанбаатар, 2022.

Окладников, 1972 – А.П.Окладников. Центральнo Азиатский очаг первобытного искусства. Новосибирск, 1999.

Наваан, 1975 – Д.Наваан. Дорнод Монголын хүрлийн үе. Улаанбаатар, 1975.

Парцингер, 2016 – Г.Парцингер. Евразийн тал нутаг дахь Скифийн үеийн морьтон нүүдэлчид. Монгол Алтайн мөнх цэвдгийн булш Монголын Пазырыкийн соёл. Улаанбаатар, 2016.

Пүрэв, 1999 – О.Пүрэв. Монгол бөөгийн шашин. Улаанбаатар, 1999.

Кубарев и др, 2005 – В.Д.Кубарев., Д.Цэвээндорж., Э.Якобсон. Петроглифы Цагаан-салаа и Бага-Ойгура (Монгольский Алтай). Издательство Института археологии и этнографии СО РАН. Новосибирск–Улан-Батор–Юджин, 2005.

The Histories, 1904 – The Histories of Herodotus. Translated by Henry Cary. New York, 1904.

Черемисин, 2008 – Д.В.Черемисин. Искусство звериного стиля в погребальных комплексах рядового населения Пазырыкской культуры. Сементика звериных образов в контексте погребального обряда. Новосибирск, 2008.

Cheremisin, 2009 – D.V.Cheremisin. On the semantics of animal style ornithomorphic images in Pazyryk ritual artifacts. *Archaeology Ethnology & Anthropology of Eurasia* 37/1 (2009). <https://doi.org/10.1016/j.aea.2009.05.010>

Чугунов и др, 2017 – К.В. Чугунов, Г. Парцингер, А. Наглер. Царский курган скифского времени Аржан-2 в Туве. – Новосибирск, 2017.

Семенов, 2003 – Вл.А.Семенов. Суглуг-Хем и Хайыракан. Могильники Скифского времени в Центрально-Тувинской котловине. Санкт-Петербург, 2003.

Сэр-Оджав, 1965 – Н.Сэр-Оджав. Монголын төв, умар хэсгийг археологийн талаар судлан шинжилсэн нь // *Studia archaeologica*. Tom. IV, fasc. 7. УБ., 1965.

Төрбат, Батсүх, 2015 – Ц.Төрбат, Д.Батсүх. Монголын Пазырыкчуудын урлагийн судалгаа.

Монгол-Францын археологийн нээлтүүд хорин жилийн хамтын ажиллагаа – Үзэсгэлэнгийн каталог, Улаанбаатар, 2015.

Түвшинжаргал, Анхсанаа, 2023 – Т.Түвшинжаргал, Г.Анхсанаа. Хадны зураг дахь үхэр тэрэгний дүрслэл. // *Studia Archaeologica*, Tom XLII, Fasc 9, т. 92-107. Institute of Archaeology, Mongolian Academy of Science. Улаанбаатар, 2023.

Цэвээндорж, 1977 - Д.Цэвээндорж. Шинээр олдсон хадны зосон зураг // *Studia archaeologica*. Tom. VII, fasc. 4. Улаанбаатар, 1977.

Цэвээндорж нар, 2005 – Д.Цэвээндорж, В.Д.Кубарев, Э.Якобсон. Арал толгойн хадны зураг. Улаанбаатар, 2005.

Цэвээндорж нар, 2010 – Д.Цэвээндорж, В.Д.Кубарев, Э.Якобсон. Шивээт хайрханы хадны зураг. Улаанбаатар, 2010.

Цэвээндорж, Төрбат, 2016 - Д.Цэвээндорж, Ц.Төрбат. Пазырыкийн соёлын хадны зураг. Улаанбаатар, 2016.

Цэрэндагва, Цэвээндорж, 2016 – Я.Цэрэндагва, Д.Цэвээндорж. Далан түргэний хос толгойн хадны зураг. Улаанбаатар, 2016.

Эрдэнэбат, 2014 – У.Эрдэнэбат. Монгол шувуулахуй. Улаанбаатар, 2014.

Эрдэнэбат, 2023 – У.Эрдэнэбат. Хар чулуутын палеолитын хадны зураг. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*. Vol. 12 (1), No. 1, Улаанбаатар, 2023. <https://doi.org/10.22353/mjaae.2023120101>



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.